



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 24 өдөр

Дугаар 0/400

Хэрлэн сум

Судалбар зургийн ажил зохион байгуулахад хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.3 дахь хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2 дугаар зүйлийн 2.1.5, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны хорин долоодугаар Хуралдааны 8 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Хэнтийн түүх-Бидэнд чухал” арга хэмжээний хүрээнд Олон Улсын зураач, уран бүтээлчдийн “Онон гол” судалбар зургийн ажлыг 2024 оны 09 дүгээр сарын 10-аас 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдрүүдэд Норовлин, Дадал, Баян-Адарга, Биндэр, Батширээт сумдын байгалийн онцлог түүхэн газруудаар зохион байгуулахад 7,500,000 (долоон сая таван зуун мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Үйл ажиллагаанд зарцуулах 6,000,000 төгрөгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зардлаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Х.Баярбаатар)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Зоригтбаатар)-д, 1,500,000 төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ